БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ . . . . . Г.БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2024/07/08 Дугаар № 277/2024 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр хаяг:	Нийслэлийн ерөнхий боловсролын 13-р сургууль
2. Барилгын байршил,мэдээлэл:	Баянгол дүүрэг, 13-р хороо, Хасбаатарын гудамж, Е-Март худалдааны төвийн хойд талд, 640 хүүхдийн Сургуулийн өргөтгөлий барилга
3.Холбох нөхцөл	1. УДДТ-149 2-р хэлхээний гадна шугамыг шилжүүлэх ажлыг зураг төслийн шатанд хангагч, түгээх, шугам эзэмшигч байгууллагуудтай нарийн зөвшилцөх 2. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг хангаж төлөвлөх
4.Холбогдох цэг, байршлын зураг, схем, техникийн өгөгдөл:	7и магистраль, ДХ7132 цэгээс холболттой УДДТ-149 ийн 2-р хэлхээнд холбогдох

-Холболтын цэг дээр байх түрэлт	15	м
-Шугамын статик даралт	20	м.у.б
-Буцах шугамын даралт	5.8	ата
-Гадна агаарын тооцоот температур	-39	0 С
-Температурын график	95/65	0 С

5. Дулааны эрчим хүчний хэрэглээ:

Нийт :	**0.63**	**Гкал/цаг**
А.Халаалт	0.47	Гкал/цаг
Б.Хэрэгцээний халуун ус	0.16	Гкал/цаг
В.Салхилуулга	0.00	Гкал/цаг

6. Дулаан дамжуулах, түгээх сүлжээ, дулаан дамжуулах төв, дулааны узель болон тоноглолд тавигдах шаардлага:

6.1 Төлөвлөж буй барилгад төвлөрсөн дулаан хангамжийн техник ашиглалтын шаардлага хангасан холигч насосны узель суурилуулах.

Салхивчийн дулааны хэрэглээг эрчим хүчний хэмнэлттэй өөр эх үүсвэрээр хангахаар зураг төсөлд тусгах.

6.2. Горим ажиллагаа доголдож хүндрэлтэй нөхцөл үүссэн үед өөрсдийн барилгын дулаан хангамжийн найдвартай байдлыг хангах нэмэлт эх үүсвэр төлөвлөж байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах.

6.3 Барилгын дотор халаалтын системд балансын хаалт, термостат суурилуулах.

6.5 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах шугам хоолой, тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи байх.

7.Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага:

7.1. Дулааны эрчим хүчний тооцоонд "Хэмжил зүйн тухай хууль"-ийн 9, 10 дугаар зүйлийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилт, улсын баталгаажуулалтад хамрагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн, дулааны тоолуурын лабораториор шалгагдсан, баталгаажуулалтын гэрчилгээ бүхий тооцооны хэмжих, тооцох хэрэгслийг суурилуулна.

7.2. "Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм"-ийн 6 дугаар бүлэгт заасны дагуу хангагч "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-иас дулааны эрчим хүчийг хэмжих тооцох хэрэгслийг суурилуулах техникийн нөхцөл авах

8.Зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлага:

8.1 Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 2.2-т заасан дамжуулах төв, дулааны шугамын хамгаалалтын зайг мөрдөн, барилга байгууламжийг төлөвлөх, мөн дүрмийн 2.6, эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т заасны дагуу хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, гэр хашаа барих, барилгын тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.

8.2. Дулааны шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.

8.3. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох явцад трассын дагуух зам талбай, ногоон байгууламжийг сэргээх, тохижилт хийх болон дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах.

8.4. Гадна дулааны шугам хоолой болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм норматив нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.

8.5. Дулааны шугам сүлжээ авто зам доогуур огтлох нөхцөлд нэвтрэх сувагтай байхаар төлөвлөн, зураг төсөвт тусгах.

8.6. Гадна дулааны шугам сүлжээний зураг төслийг боловсруулан хангагч байгууллага "Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК-тай зөвшилцөн, хянуулж, батлуулан 1%-г хүлээлгэн өгөх.

8.7 Төлөвлөж буй барилгын 10-аас дээших давхарт шаталсан халаагчтай байхаар зураг төсөлд тусгах

9.Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам:

9.1. Дулааны шугам сүлжээ, тоноглолын зураг, төсөв боловсруулах, барилга угсралт, туршилт, тохируулгын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад дараах хууль, дүрэм, журам, барилгын норм ба дүрэм, стандартуудыг мөрдөж ажиллана.

9.1.1. Эрчим хүчний тухай хууль

9.1.2. Барилгын тухай хууль

9.1.3. Хэмжил зүйн тухай хууль

9.1.4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"

9.1.5. Дэд бүтцийн сайдын 2003 оны 125 дугаар тушаалаар батлагдсан "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм"

9.1.6. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 127 дугаар тушаалаар батлагдсан "Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"

9.1.7. Эрчим хүчний сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар батлагдсан "Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"

9.1.8. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтын журам"

9.1.9. Барилгын норм ба дүрмүүд

9.2. Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Эрчим хүчний дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна", мөн хуулийн 30.1.13-т "нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх" гэж заасны дагуу хангагч байгууллагад хүлээлгэн өгөх, шилжүүлэх нөхцөл хангасан тохиолдолд дулааны эрчим хүчээр хангана.

9.3 Эрчим хүчний тухай хуулийн 29.1.9-д "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй" гэж заасан, мөн хэрэглэгч нь хуулийн 30.1.10-т "түгээх, зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах" гэж заасны дагуу бусад хэрэглэгчийг

9.4 Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 5.1.20-р заалтын дагуу дулаан дамжуулах 200мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугам, түүний анхдагч таслах хаалт нь эрчим хүчний дамжуулах шугам тоноглол тул түүнийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 348 дугаар тогтоолын дагуу 2Ø200мм-ээс дээш голчтой дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэх "Өмч шилжүүлэх гэрээ"-г байгуулж, хэрэгжилт бүрэн хангасан нөхцөлд

10. Техникийн нөхцөл олгосон үндэслэл:

Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2024 оны 6 сарын 4-ний өдрийн 2024/00-075 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз зураг, ОСНААУГ-ын 2024.01.04 өдрийн №08/15 тоот бичиг, Грийн ресурс констракшн ХХК-ийн 2024.02.05-ны өдрийн №24/19 тоот бичиг, НХБХГ-ын 2024.06.15-ны өдөр батлагдсан гадна дулааны шилжүүлэх шугамын байгуулалтыг үндэслэв.

11.Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа:

11.1 Энэхүү техникийн нөхцөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд буюу 7/8/2026 өдрийг хүртэл хүчинтэй.

11.2. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ.

11.3. Тус дүрмийн 2.7-д заасны дагуу техникийн нөхцөлийн хугацааг боломжтой тооцооны дүн гарсан тохиолдолд 1 удаа 1жилийн хугацаатай сунгана.

11.4. Техникийн нөхцөлийн 3 болон 11 дэхь заалт хангагдаагүйгээс хэрэглэгч холбогдоогүй тохиолдолд техникийн нөхцөл олгосон хангагч байгууллага хариуцлага хүлээхгүй.

11.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийг үндэслэн зураг төслийн байгууллагаар барилга угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төслөө хийлгэж, холбогдох байгууллагуудаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

11.6. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ. Хэрэв зураг төслийг батлуулаагүй, мөн баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн

12.Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох:

12.1.Дараах тохиолдолд энэхүү техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

12.1.1. Хүчинтэй хугацаа дууссан;

12.1.2. Энэхүү техникийн нөхцөлийн аль нэг заалт, шаардлагыг биелүүлээгүй

12.1.3. Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

12.1.4. Олгосон ачааллаас хэтрүүлэн чадал ашигласан, мөн холболтын цэгийг өөрчилсөн тохиолдолд;

12.2. Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламжийг дулаанд холбохыг хориглоно.

ЗӨВШӨӨРСӨН.
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ш.МӨНХЖАРГАЛ

ХЯНАСАН:
ҮХХ-ИЙН ДАРГА Б.ЭРДЭНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
ҮХХ-ИЙН ИНЖЕНЕР Н.ЗОРИГТБААТАР

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээдийг төлөөлж:
Хүлээн авч, техникийн нөхцөлийн шаардлагууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалтта танилцсан эсэх

☐ ТИЙМ ☐ ҮГҮЙ

Нэр . . . . . Гарын үсэг . . . . . .

Регистрийн дугаар . . . . . .
Холбоо барих . . . . . .
Огноо 20.... он .... сар .... өдөр